

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-27

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 6-7

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ 7-17

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 16 гишүүн өргөн мэдүүлсэн, 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 17-27

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 27-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 13 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Батболд, Б.Чойжилсүрэн;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Б.Батцэцэг, П.Мөнхтулга, З.Мэндсайхан.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: 1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.“Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.“Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19

63.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 16 гишүүн өргөн мэдүүлсэн, 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, А.Энхбат, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, зөвлөх А.Амармөрөн, Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2, 3, 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэхтэй холбоотой 69¹ дүгээр заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 14
Бүгд: 19
26.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3. Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 09 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 13 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралд ирвэл зохих 25 гишүүнээс ирсэн 14, ирц 56 хувьтай байна. Ирц хангалттай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Би ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Н.Алтанхуяг гишүүн, Х.Болормаа гишүүн, П.Ганзориг гишүүн, Г.Дамдинням гишүүн, Г.Тэмүүлэн гишүүн, Д.Батлут гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, Б.Түвшин гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Д.Пүрэвдаваа гишүүнээр бүртгүүлж оролцож байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Эхний асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Алт-3 аяны хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд хэлэлцэх эсэх байгаа.

Тэгэхээр төсвийн тодотгол ч бай, төсөв ч бай үйлчилж байгаа хуулийн хүрээнд хийгдэж төлөвлөгдсөн байх ёстой батлагдахдаа. Тийм учраас дагаж мөрдөж байгаа хуулиудыг эхэлж баталж байж Төсвийн хууль батлагдах ёстой. Тодотгож батлагдах ёстой. Тийм учраас бид нар Төсвийн дагасан хуулиудаа эхэлж хэлэлцэх ёстой.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүргийнхээ ажлын хэсэг байгуулах тухай тогтоол шүү. “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоол гэсэн үг.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд байгаа. Булгантуяа нарын 16 гишүүний санаачилсан хууль байгаа. Энэ хууль ер нь Төсвийн дэгд өөрчлөлт оруулах тухай ийм хууль байгаа

учраас би манай Байнгын хороогоор зайлшгүй хэлэлцэх ёстой гэж ингэж үзсэн байгаа. Энэ 3 асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё. Хэлэлцэх асуудлаа эхлээд танилцуулчихъя.

14.54 цаг

Эхний асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн. Сайд нараас хэн байгаа юм? Ажлын хэсэгт бол Болдын Жавхлан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Р.Мягмаржав Татварын Ерөнхий газар Татвар хураалт удирдлага, арга зүйн газрын дарга, Б.Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх танилцуулгыг Жавхлан гишүүн байхгүй байгаа учраас Дамдинням гишүүн танилцуулах юм уу? Дамдинням гишүүн танилцуулчихъя. Дамдинням сайд танилцуулъя.

Г.Дамдинням: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт 3 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдэд дараах агуулгатай нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд:

1.Боловсролын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор цэцэрлэг ЕБС-ийн зориулалтаар барилга байгууламж шинээр барьсан бүх аж ахуйн нэгж байгууллагуудад татварын хөнгөлөлт олгох зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд

2.Төрийн албан хаагчийн цалин хөлс 1 удаагийн буцалтгүй тусламжтай холбоотой зарим зохицуулалтыг цэгцлэх. Нэмэлт өөрчлөлтийг Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд;

3.Жилийн төсвийн хуулиар баталсан төвлөрүүлэх орлогыг дайчлах, төсвийн сахилга батыг чангатгах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд

4.Төсвийн сахилга бат, зардлын хэмнэлт, үр нөлөөтэй санхүүжилтийн үндэс суурийг тавихад чиглэсэн цогц арга хэмжээг “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд

5.Алтны геологийн судалгаа, эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлж, гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлэх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тус тус тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Дамдинням сайдад баярлалаа. Хууль санаачлагчийн танилцуулгаас асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя.

Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Би энэ төсвийн тодотголтой холбоотойгоор төрийн албан хаагчдыг тодорхой тоо хэмжээгээр хэвлэлээр авсан мэдээллээр 14 мянган төрийн албан хаагчдыг цомхотгоно гэсэн байгаа. Энэ 14 мянгыг хэрхэн тооцож гаргасан юм бэ? Энэ тодорхой энэ сошиалаар явж байгаа мэдээллээс харахад энэ төрийн байгууллагуудыг хувьчлаад хасчихсан байна гэсэн ийм мэдээлэл авсан. Жишээгээр агентлаг байлаа гэхэд 9 хувийг нь хувьчлаад орон тоог нь цөөрүүлсэн гэсэн ийм мэдээлэл явж байна. Энэ хэр бодитой вэ? Хэрвээ та бүхэн маань ямар нэгэн тооцоо судалгаагүйгээр тухайн байгууллагынхаа жишээгээр 9 хувийг шууд цомхотголд оруулчих юм бол зарим байгууллагууд нь хиймлээр орон тоогоо өсгөчихсөн үнэхээр тэр цомхотгох ёстой магадгүй 30 хэдэн хувь ч байдаг юм уу цомхотгох ёстой газар байж болно. Зарим байгууллагууд нь үнэхээр тэр төрийн захиргааны албан хаагчид нь мерит зарчмаараа олон жил ажиллачихсан нөхдүүдийг хоморголон халах тийм хийдэл гараагүй гэдгийг хэрхэн яаж нотолж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Дараа нь энэ 14 мянган иргэн маань Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахад ердөөсөө 70 мянган төгрөг төлөөд л шүүхэд оролдлого хийнэ. Та бүхний гаргасан шийдвэр хууль зүйн хувьд үндэслэлгүй болох юм бол шийдвэр гаргасан этгээд цалинг нөхөн олгох ёстой. Энийг тооцсон уу? Тэгээд тодруулъя.

Ц.Даваасүрэн: Чухал асуудал асууж байна. Ер нь төсвөөс сүүлийн 3 жилд 3 дахин нэмсний хор, гайг 10 хэдэн мянган төрийн албан хаагч нар үүрэх болж байгаа байхгүй юу. Буруу төлөвлөсний хар гайг. Тийм учраас та нар яг тэр бодитой хасагдах ёстой газрыг нь олсон уу л гээд байна шүү дээ. Одоо хэтэрхий орон тоогоо нэмчихсэн, хэтэрхий байгууллагынхаа үйл ажиллагааг тэлчихсэн ийм газруудаа олж хийсэн үү? Энэ тэтгэмжийн мөнгө чинь ялгаа байхгүй төсөв дээр суугаад ирэхээрээ хэмнэлт биш болох юм биш биз дээ гэдэг зүйлийг асуугаад байгаа учраас энэ асуудалд тодорхой хариулмаар байна. Хэн хариулах вэ? 5, Ганбат дарга.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн албан хаагчтай холбоотой 9 хувийн асуудлыг Улсын Их Хурлаар сая батлагдсан Хөгжлийн жилийн төлөвлөгөө батлуулахад 9 хувиар төрийн албан хаагчдыг тоог бууруулна гэдэг энэ тоо Улсын Их Хурлаар батлагдчихсан. Энэ хүрээндээ энэ тоо эхнээсээ хаанаас яаж гарсан бэ гэх дээр Эдийн засаг, хөгжлийн яамны жилийн төлөвлөгөө боловсруулсан. Энэ үедээ энэ төрийн албан хаагчдыг 9 хувь бууруулах бололцоотой юм аа гэдэг энэ тооцоо судалгааг тухайн үед Улсын Их Хурал дээр тухайн үед жилийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулан ингэж Улсын Их Хуралд үүрэн барьж батлуулсан.

Бид энэ 9 хувиар төрийн албан хаагчдаа бууруулах асуудал дээр багш, эмч нар хамаарахгүй. Багш, эмч нараас бусад төрийн албан хаагч дээр бид Сангийн яам тусад нь судалгаа хийгээд сул орон тоонуудыг гаргуулсан. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсад цалин авч байгаа сул албан хаагчдын тоог гаргаж үзэж байгаад энэ дээрээ бид бас тоонуудыг нь дахиж нягтлуулж үзлээ. Энэ сул орон тоог үзэхэд багш, эмч нараас бусад газар дээр 6 мянган сул орон тоо байна гэдэг гарсан. Гэхдээ энэ дээр сул орон тоонуудыг бас ажил юуны Төрийн албаны энэ тэр дээр бас ярилцаж байгаад энэ яг 6 мянган сул орон тоог яаж гаргасан юм бэ гэх дээр төрийн албаны системээр цалин бас олгодоггүй. Яг өнөөдөр Монгол Улсад цалин хөлсний системээр цалин авч аваад цаана нь 6 мянган хүний сул орон тоо байна аа гэдэг энэ тоо. Дээрээс нь энэ тоог гаргахдаа жирэмсний амралттай байгаа хүмүүсийн орон тоог бид нар хасаад ингэж гаргасан сул орон тоо байгаа.

Засгийн газрын хуралдаан дээр энэ 9 хувиар бууруулах асуудлыг бас ярихдаа гол үндэслэсэн юм энэ сул орон тоон дээр үндэслэж энэ төрийн албан хаагч, одоо яг төрийн албыг ажлаа хийж байгаа төрийн албан хаагчдыг ямар нэгэн байдлаар цомхотголд оруулахгүйгээр сул орон тоо, ажлын байрны давхардал, ажлын байрны нягтрал энэ байдалтай уялдуулан энэ сул орон тооноос хэмнэх байдлаар энэ цалингийн санг гарга аа гэдэг ийм чиглэл Засгийн газрын хуралдаанууд дээрээс өгөгдсөн.

Яг энэ сул орон тооны тооцоог хийж үзээд нийт улсын хэмжээгээр бид 12800 мянган орон тоог нь сул орон тоонд хамруулах бололцоотой юм аа гэдэг ийм байдлаар авч үзсэн. Нөгөө талдаа төрийн албан хаагчдыг бас ямар нэгэн байдлаар ажлаа гүйцэтгэж байгаа албан хаагчид хүндрэл учруулахгүй байхаар

Төсвийн тодотгол батлагдсаны дараа төсвийн ерөнхийлөн захирагч нар нь өөрсдөө төсвийнхөө хүрээндээ энэ ажлын ачаалал, чиг үүргийн давхардалтайгаа уялдуулан байдлаар оновчтойгоо тогтоох замаар энийг хийх ёстой юм аа гэдэг ийм байдлаар Засгийн газрын хуралдаан дээр яригдсан. Төсвийн тодотгол баталсны дараа Засгийн газрыг Хэрэг эрхлэхийн газрын Дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг бас энэ дээр ажиллаж байгаа. Энэ дээр Засгийн газрыг Хэрэг эрхлэхийн газраас хяналт тавих.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Тодруулъя. Жирэмсний, декретийн сул орон тоог оруулчхаж байгаа юм уу? Пүрэвдаваа гишүүн. Сургалтад явсан энэ тэрийг.

Д.Пүрэвдаваа: Ганбат дарга аа Засгийн газар дээр ярьсан асуудал чинь танай дотоодод руугаа чиглэсэн асуудал шүү дээ. Танай Засгийн газрын бүтцийн гүйцэтгэх засаглалын асуудал байхгүй юу. Та нар хоорондоо ярьсан зүйлээ бид нарт ярьсан юм шиг битгий ойлгуулаад байгаач. Өнөөдөр танд тарааж өгсөн материалын тэдийн тэд дээр ийм тайлан тооцоо байгаа гэж танилцуулах ёстой биз дээ. Гэтэл Улсын Их Хурлын гишүүдэд тарааж өгсөн материал дээр чинь 14 мянгын гаргалгаа нь огт алга байна. 228 мянган төрийн албан хаагч байгаа гэдэг надад мэдээлэл байна. Тэрнээс захиргааны 10 хувь нь, тусгай төрийн тусгай нь албан хаагч 20 орчим хувь байдаг. Үйлчилгээний 70 орчим хувь байна гэсэн ийм мэдээлэл байгаа юм. Улс төрийн 1.7 хувь. Ингээд эдгээрээс хэрхэн яаж ямар шалгуураар үйлчилгээнээс нь хэдийг хассан юм? Төрийн захиргаанаас нь хэдийг хассан юм? Төрийн тусгай албан хаагчдаас хэдийг хассан юм?

Ц.Даваасүрэн: Ганбат хариулах уу? 5.

Ж.Ганбат: Бид, би засаг дотроо ярилцаад л төсөв дээрээ, төсвийн тодотгол дээр ийм бодлого баримталж энэ 9 хувийн төрийн албан хаагч нарын тоог бууруулахыг ийм сул орон тооныхоо үндсэн дээр бууруул аа гэдэг ийм бодлого гаргаж, төрийн албан хаагч дээр, ажлаа гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч дээр ямар нэгэн байдлаар асуудал үүсэхгүйгээр гэдэг ийм байдлаар гаргасан гэдгээ л хэлээд байгаа шүү дээ. Энэ бол зарчим, бодлогоо, наадхыг чинь бид нар өргөн барьсан танилцуулга дээр байгаа. Яг тараасан наад материал манайх яг юундаа, бид нар өргөн барьсан юман дээр ингэж тооцсон гээд юмнууд байгаа л даа төсвийн. Тийм 9 хувийг би сая уг нь хэлэх үгэндээ би харин энийг харин сая эхэндээ хэлсэн нь жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан Засгийн газарт танилцаад Улсын Их Хурал батлуулахад 9 гэж ярьсан тухайн үед. Улсын Их Хурал Засгийн газрын хуралдаан дээр яагаад 5 биш, яагаад 10 биш, 9 гэдэг үндэслэлүүдээ энэ тэр яриад батлаад.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Та нарын тайлбар яг энэ амьдрал дээр болоод байгаа юм 2 өөр болчихоод байгаа юм. Одоо бид нар руу л утасдаад эхэлчихсэн байгаа байхгүй юу. Манай орон тоог ингээд миний орон тоо асгаад нэгтгэчихсэн чинь минийх хасагдах гэж байна энэ тэр гээд л яриад эхэлчихсэн байна лээ төрийн албан хаагч нар. Одоо тэгээд яах вэ төрийн албан хаагч нарыг санал өгдөггүй л гэж бодоод байгаа юм байлгүй дээ. Тэд нар чинь сонгуулиар саналынхаа дүнг өгөх байлгүй дээ.

Дараагийнх нь Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Би уг нь асуулт асууя гэсэн энэ хариулах хүн байхгүй шүү дээ. Энэ Ганбатаасаа юугаа нэгдүгээрт сайд, хоёрдугаарт би ийм байна Даваасүрэн

дарга аа энэ манай засгийнхан энэ чинь зүгээр төсвийн тодотгол биш шүү. Сая өмнөх Засгийн газрыг ийм юм болохгүй байна гээд огцруулаад шинэ Засгийн газар гарч ирсэн. Би шинэлэг юм хийх болов уу гэж амьхандаа горьдож, олон нийт ч бас наад нөхдүүдийгээ жаахан юм хийгээд бай, хийгээрэй гэж хэлээрэй гээд байгаа байхгүй юу. Энэ намайг Сангийн сайд байхад л энэ нөхөр суудаг байсан. Манай Ганбат муу хүн биш л дээ. Бодлогын газрын дарга байсан. Одоо явсаар байгаад хааж очсон юм. Үгүй ээ ингэж бид нар асуудал ярих юм уу? Тэр шинэ Ерөнхий сайд чинь Улсын Их Хурал дээр орж ирээд энэ өмнөх өмнөх төсөв мөнгөн дээр бол ийм ийм асуудлууд байна аа нөхөд, ийм ийм зовлон бэрхшээл бас байна, ингээд төсвийн алдагдал ихэссэн байна, энийг бид нар ингэж ингэж багасгая гэж бодож байна. Тэгэнгүүтээ шууд хэдэн хүнийг хална гэж оруулж ирдэг чинь ер нь зөв юм уу? Би хүн халахгүйгээр ер нь халж бас болно.

Ялангуяа энэ Пи Ар-ын чиглэлийн хүмүүсээ хасмаар байна. Засаг биш шүү. Их Хурал хүртэл оролцоно шүү. Хуучин 10 хэдэн хүнтэй байдаг манай Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 100 арай хүрэхгүй хүнтэй байсан. Одоо 200 гаруй хүнтэй. Одоо энэ хэвлэл, мэдээллийн алба гэж туслах маягийн юм байсан чинь бүр бүр томоо данхар болчихсон гэх мэтчилэн яривал ийм юмнуудыг янзлах ёстой. Энэ бол хүн алах тухай асуудал биш байхгүй юу. Бүтцийн өөрчлөлт хий л дээ. Том өөрчлөлт хийгдэнэ. Мангар их гадаадын зээлүүд авчихсан. Тэр зээл чинь л өдрөөс өдөрт хүү нь яваад онигоонд орсон шүү дээ. Зээлээ ашиглаж авч дуусаагүй байсан чинь төлөх хугацаа нь болчихсон. Ийм ийм хариуцлагагүй дампуурсан юмнуудыгаа ингэж ингэж өөрчилнө гэж Монгол Улсын Ерөнхий сайд орж ирж Улсын Их Хурал дээр ард олон нийтэд энэ Их Хурлын гишүүдэд бодлогоо танилцуулах хэрэгтэй.

Тэрний дараа хэдүүлээ энэ энэ бөөс хуурс руу нь ормоор байна энэ. Одоо бол энэ шууд хэдэн хүн халах тухай яриад л л олон нийт рүү наад мессеж чинь буруу. Танай Засгийн газар, танай Засгийн газар гэсэн хэн энд? Даймаа л байна уу? Энэ шинэ сайд нь чих нь халууцдаг юм Батлут та нар. Одоо яая гэх вэ дээ та нар нэгэнтээ ажил хийх гэж сайд болсон юм байгаа биз дээ? Үгүй ээ тэр Ерөнхий сайддаа хэл, Сангийн сайддаа хэл. Үгүй ээ Жавхланг оруулж ирээд бас нэмэргүй дээ. Уг нь энэ Тэмүүлэнгээ тавьчихгүй та нар. Тэмүүлэнгээ тавьчихсан юм бол бас жаахан ганц, хоёр, үгүй ээ хүнээ хүртэл олгохгүй. Үгүй ээ нээрээ, та нар нээрээ жаахан тоглоом биш шүү. Энэ ард түмний ахуй амьжиргаа ингэж. Одоо тэгээд наадам дөхчихсөн. Бараг энэ хавар олигтой хуралдаагүй шүү дээ. Одоо гэнэтхэн л сүүлд нь л довтолгож байна. Ингэж довтолгож болохгүй. Би зарчмын санал хэлээд байна. Ерөнхий сайд Улсын Их Хурлын чуулган дээр бодлогоо танилцуулаад ийм ийм юмнуудыг ингэж ингэж өөрчилмөөр байна аа энэ дээр Улсын Их Хурал дэмжлэг үзүүлээд өгөөч. Ард иргэд маань ийм ийм нөхцөл байдалтай байна. Ийм ийм юмыг бид ингэж ингэж хийнэ, ингэхээс өөр аргагүй боллоо. Үгүй ээ яагаад энийгээ дахиад л их хурлаасаа тусдаа, ард түмнээсээ салангид, хэдэн ...-гуудаар тойроод л юу гэдэг билээ тойруулагдсан, вакумжсан дахиад ийм хүмүүс гарч ирэх вий дээ. Батлутаа би бид хоёр Эрдэнэтээс хамт байсан. Чи бас сарын дараа танихаа больдог байхгүй юу эд нар чинь. Үгүй ээ ийм юмнуудыг л болиод өг л дөө. Энэ орж ирж байгаа асуудал үндсээрээ буруу. Эхлэл чинь буруу байна. Би Ганбат руугаа хэлээгүй шүү. Энэ засаг руу хэлж байгаа юм. Мордохын хазгай гэж монгол ардын их айхтар үг байдаг юм шүү дээ. Та нар анхнаасаа зөв мордчих л доо. Зөв мордоод жаахан алхуулаад, таваргаад жаахан явж байгаад. Шууд л пуужин дээр суугаад л хэдэн амьтан толгойг нь аваад.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Санал юм байна шүү дээ. 1 минут нэмээд өгчих.

Н.Алтанхуяг: Би 1 минут хэлье. Үгүй ээ би асуух гэсэн чинь Ерөнхий сайд чинь байхгүй, Сангийн сайд чинь байхгүй. Би энэ Даймий энэ 2 хэдхэн хоногийн өмнө зэрэгцээд сууж байсан хоёроосоо та хоёроос асууя гэх юм уу. Одоо боль л доо та нар. Тэр ажил хариуцаж байгаа хүмүүсээ оруулж ирээд асуу л даа. Хамгийн гол нь ард түмэндээ нээлттэй, ил тод байгаа байдлаа яриад болохгүй байгаа юмнуудаа хэлээд энэ энийг нь ингэж ингэж өөрчилнө жаахан дайчин давшингуй ажилла л даа. Би больё. Би ер нь ч суухаа ч болилоо өнөөдөр бас.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Сайхан сайхан улс төрөө хийчихлээ. Энэ одоо тэр сайд нар орж ирээд танд хариулах гээд орж ирээд байна шүү дээ.

Гишүүд асуултаа асууж дууслаа. Ер нь тэгэхдээ бас энэ төсвийн асуултаа Сангийн сайдыг дууд дууд. Оруулж ирэхгүй бас.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг байна уу?

Түвшин гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлье. Ирцээрээ болчхож. Пүрэвдаваа гишүүн асууя.

Д.Пүрэвдаваа: Түрүүний асуулт дээрээ хэлж чадаагүй хэдэн зүйл байна. Төсвийн байнгын хорооны өмнөх хурал дээр Эдийн засгийн яамнаас тэр инфляц тооцсон аргачлалыг авъя гэсэн. Сайдын тушаал өгсөн болохоос биш яаж 9.5-ыг гаргасан, яаж 5.5-ыг гаргасан тэр тооцооллуудаа өгөөгүй. Тэгээд хууль дээдлэх зарчмаар төрийн алба ажиллах ёстой гэдэг юм байгаа. Хэрвээ та бүхэн минь хариулт өгөхгүй бол дээд шатны байгууллагад нь хандах эрх нь надад байгаа. Тэрийг ялангуяа Эдийн засгийн яаманд хандаж хэлмээр байна. Зөрчилтэй шийдвэр гаргасан, хууран мэхлэх үйл ажиллагаа явуулсан гэж хандах болно гэдгээ хэлмээр байна.

Дараагийнх нь энэ улс төрийн албан тушаалтан 228 мянган төрийн албан хаагчдаас хэд нь хасагдах гээд байгаа юм? Захиргааны албан хаагчдаас 22 мянган хүнээс хэд нь хасагдах гээд байгаа юм? Төрийн тусгай буюу энэ цэрэг, цагдаагаас хэд нь хасагдах гээд байгаа юм? Үйлчилгээ нь миний ойлгож байгаагаар багш, эмч нар 70 орчим мянга байгаа байх. Бусад үйлчилгээний салбарынхан, ТҮК-ийнхэн гэх мэт энэ ажилтнуудаас хэд нь хасагдах гээд байгаа юм? Танай 14 мянган задаргааг ямар зарчмаар шийдвэрлэсэн талаараа яг энэ хуулийн төсөл яаралтай горимоор орж ирсэн шиг яаралтай горимоор хариу өгнө үү гэж хүсэх байна. Төрийн нарийн бичгийн дарга аа хэзээ өгч чадах уу? Яаралтай болохоор та бүхэн яарч чадаад байдаг гэдгийг хараад байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн мэдээлэл авъя гэхээр зэрэг гөлөг төөрүүлж байгаа юм шиг шал утгагүй утгагүй юм өгөөд. Та өөрийн гарын үсэгтэйгээр өгчихвөл сайн байна шүү.

Ц.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүний мэдээллийг гаргаад өгчхөөрэй. Ер нь шаардлагатай хариулт авсангүй гэж үзсэн байна. Түвшин гишүүн үг хэлье.

Б.Түвшин: Өнөөдөр эдийн засгийн хямрал дээрээс нь энэ уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ цэн буурч байгаатай холбогдуулаад гэж ойлгож байгаа боловч нөгөө талаасаа бид нар яг байх газар руу л түлхэж байна л даа. 10-аадхан жилийн өмнө хэдүүлээ 15 их наядын нийт төсөвтэй болоод л байсан. Энэнээс хойш их огцом өссөн. Тийм учраас зарчмын хувьд дэмжиж байгаа. Орж ирж байгаа

бүх хасах, танах болгоныг бол дэмжинэ. Яагаад гэвэл энэ урсгал зардлыг 15 их наядтай болгож байж бид нар цаашдаа валютын болон энэ гадаад уул уурхайн бүтээгдэхүүний эрсдэлээс хамгаалагдах юм. Харин цаашдаа энэ урсгал зардлыг нэмэхгүйгээр илүү үнэхээр өгөөж гардаг юм бол тэрийгээ тэр хөрөнгө оруулалт марк руу хийхгүй бол өнгөрсөн хэдэн жилийн уул уурхайн энэ өсөлтийг бид нар бол эдийн засагтаа үр ашигтайгаар огт ашиглаж чадсангүй. Тийм учраас дахиад хэлье. Энийг бол дэмжинэ. Цаашдаа бүүр урсгал зардлыг 15 их наяд хүртэл дэмжих хэрэгтэй.

Харин Эдийн засаг, хөгжлийн яаманд анхааруулах зүйл байгаа нь ерөөсөө энэ Монгол Улсын төсөв өөрөө төвлөрсөн болчихсон. Орон нутаг, тэр тусмаа сум, аймгууд бол өөрийнхөө төсвөөрөө юугаа хийдэг, юугаа хөгжүүлдэг, цаашаа бие даагаад хөгжөөд явах энэ боломж бараг байхгүй. 1 сумын жорлон барьж байсан ч гэсэн улсын төсвөөс л авч байдаг. Энэний чинь цаана л уул, уурхайн орлогууд байж байгаа. Тэгэхлээр энэ сум орон нутгууд яаж хөгжих юм, ялангуяа өөрсдөө бие даасан байдлаар юу юугаа хариуцах юм, Улсын төсвөөр ерөнхийд нь юуг нь хийх юм, юуг нь хийхгүй байх юм гэдэг юмаа нэгдүгээрт зааглах зайлшгүй шаардлагатай байгаа.

Хоёрдугаарт энэ цалин, хөлс, урамшууллын систем байх нь байна. Гэхдээ салбар болгон дээр өөр. Одоо салбар болгон л лоббидсоор байгаад үүнийгээ уралдаж нэмдэг болчихсон. Энийг горимд оруулах хэрэгтэй. Монгол Улс чинь ажил мэргэжлээр үл шалтгаалаад төрийн албан хаагч гэдэг ганцхан зарчим руу л орохгүй бол зарим салбарт ажиллаж байгаа нь элдэв долоон нэмэгдлүүд аваад байдаг. Зарим салбарт ажиллаж байгаа нь авч чаддаггүй учраас дараагийн удаа тэрийгээ нэмэгдүүлэх гэж ингэж орилдог. Тэгээд цалин нэмэгдлийн уралдаан болоод явчхаж байна.

Гуравдугаарт тэр хөрөнгө гэж нэрлээд байгаа тэр сум орон нутаг дээр байгаа тавиад байгаа зардлууд чинь эргээд зардал нэхээд байгаа шүү дээ. Тийм учраас эцсийн дүндээ Монгол Улс орон нутгаасаа эхэлж хөгжинө, Монголчууд юу хийдэг юм тэр хөдөө аж ахуйн, мал аж ахуйгаасаа хөгжинө, бие даасан эдийн засгийн нэгжүүдээсээ хөгжинө. Энэ бодлогыг яг энэ хүндрэлтэй төсөв, санхүү ярьж байгаа хүн болгон урсгал зардлаа хасъя гэж ярьдаг болсон байна. Яг энэ цаг үед зөв чиглүүлэх ёстой. Ер нь энэ хасъя гэсэн гэхээсээ илүү хасагдах ёстой. Цаашдаа ч улам хасагдах ёстой. Зөв хэмжээ рүүгээ очих ёстой. Түрүүний тэр Алтанхуяг даргын бас хэлдэг зөв шүү.

Ер нь бол энэ Ерөнхий сайд энэ Засгийн газраас том зургаараа ийм бодлого явуулна, ийм үр дүнд хүргэнэ. Та бүхэн маань дэмжээд өгөөрэй гэж хэлж байгаад дотор нь нэгдүгээр алхам, хоёрдугаар алхам, гуравдугаар алхам гэж явбал гишүүдэд ч гэсэн илүү ойлгогдоно. Дараа нь нэг бүрчлэн хэсэгчлэн булангаас нь ороогоод байхгүй эцсийн үр дүнд хүрэх эдийн засгийн тэр тэнцвэрт хүрэх тэр цэг рүүгээ зөв явчих байх шүү. Тэрийг бас та хэд бас үгийг нь авч ашиглаж энэ асуудлаа ойлгуулах тал дээр бол давуу тал болгож ашиглах хэрэгтэй гэж ингэж бодож байна.

Тийм учраас дахиад энэ хэлье одоо энд орж ирэх, цаашдаа намар орж ирэх төсвийг ийм үр дүнтэй болгох юм аа гэдэг бодлогоо бас түлхүү ярьж, ойлгуулж бас гишүүдээсээ дэмжлэг авч ажиллаарай гэж та бүхэнд хэлэх байна.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн үг хэллээ. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амар ам амгаланг айлтгая. 25 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаад хууль, тогтоолын төслүүд ороод ирчихсэн юм. Үүн дээр ярихаар юмнууд бас бидэнд байгаад байгаа. Дан дамаа тэр Төрийн албаны хуульд оруулах гээд байгаа нэмэлт, өөрчлөлтийг эрхлэх асуудлынх нь хүрээнд Төрийн байгуулалтын байнгын хорооноос нь саналыг нь авч тэр санал, дүгнэлтийг бид энд хэлэлцэх ёстой. Төрийн албаны зөвлөлийн дарга байж байна. Энэ төрийн албаныхаа асуудал дээр та хэд нэлээн санал, дүгнэлтээ гаргасан юм байгаа байлгүй дээ. Би энэ том төр, үрэлгэн төсвийг бууруулах талаар байр суурь нэгтэй байдаг хүн.

Гэхдээ байдлыг засаж байгаа нь энэ гээд таамаг юм хийж таарахгүй. Ямар бүтэцтэй, ямар чиг үүргийг ямар бүрэлдэхүүнээр хийх юм гэдэг юм чинь тодорхой болж байж хаанаа юу нь засагдах юм гэдэг юм яригдах ёстой. Энэ үзэл баримтлал энэ тооцоолол чинь бэлэн болсон юм уу та хэдэд? Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод гэдэг юм уу, хувийн хэвшилд гэдэг юм уу шилжүүлнэ гээд л ярьдаг юм. Үгүй ээ юунд шилжих гээд байгаа юм? Тэр шилжих юмаа тодорхой болгооч. Тэгээд төрийнхөө энэ үндсэн бүтцээс тэрийгээ чөлөөлөөч. Тэгээд тэр цаад эрх мэдэлд шилжүүлж байгаа байгууллагуудтайгаа ямар гэрээ контракттай, ямар хяналттай, харилцан тэнцэлтэй явах юм гэдэг юмаа эрх зүйн хувьд тодорхой болгооч. Сая энэний ар дээр л энэ зүйл яригдах ёстой шүү дээ. Тийм учраас би Төрийн албаны тухай хуульд оруулах гээд байгаа өөрчлөлтийг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцүүлэх нь зүйтэй. Тэгж байж ярьсан нь дээр гэсэн ийм саналтай байна . Нэг.

Хоёр дахь зүйл тэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр сургууль ,цэцэрлэг барьчихсан хүнд тодорхой татварын хөнгөлөлт эдлүүлье гэдэг юм яригдаад байгаа юм. Барьсанд нь биш ээ, бариад ашиглаад, төрийн ачааг үүрэлцээд явж байгаа хүнд л тэгэх ёстой. Тэгэхээр үүнийг тодотгож барих юмнууд байна гэж нэг ийм зүйл байна.

Хоёр дахь зүйл. Тэр Төсвийн тухай хууль дээр орж ирээд байгаа тэр 3 дахь зүйлийг бид харах ёстой. Хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн татварын орлогыг тодорхой салбар, үйл ажиллагаа руу чиглүүлэхгүй гэсэн заалт яваад байгаа юм уг нь. Гэтэл хуульд өөрөөр заагаагүй гэдгийг нь аваад хаячихаар тэр чигтээ өөр салбар үйл ажиллагаа руу чиглүүлэхгүй гэсэн санаа нь үлдэж байгаа юм. Наад тамхины гаалийн татварыг чинь нэмэгдүүлэх асуудал зөв шүү дээ. Тэр нэмэгдүүлж байгаа хэсгийг иргэдийнхээ гэдэг юм уу, энэ залуу үеийнхээ эрүүл мэндийг дэмжих, соён гэгээрүүлэх гэдэг юм уу чадамж бий болгох чиглэл рүү тусгайлан зарцуулна гээд зааж өгөх нь хамгийн зөв байхгүй юу. Ард түмэнд хэлсэн ч амар. Бид татвар нэмээгүй. Нийгэмд сөрөг нөлөөтэй, иргэдийн эрүүл мэндэд сөрөг үйл ажиллагаатай ийм зүйл дээр татвар нэмсэн. Буцаагаад энэ улс орны ирээдүйн иргэдийг бид эрүүл, саруул ухаантай бас зөв явах үүднээс нь энэ рүү нь энэ мөнгийг нь чиглүүлж байгаа юм гээд дуугарах ёстой байхгүй юу. Хамгийн дэмжих ёстой зүйлээ аваад хаячхаж байгаа байхгүй юу. Болохгүй шүү дээ энэ чинь. Дэлхийн улс орнууд энэ рүүгээ явчихсан шүү дээ. Бид хэд энд өөр юм яриад суугаад байж таарамгүй байна. Тийм учраас би үүнийг энэ талаас нь хараасай гэж ингэж бодож байна.

Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулж авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ байгаад байгаа юм. Тогтоол байгаад байгаа юм. Бас ганц нэг зүйл дуугармаар. Төрийн албаны хуулийн өөрчлөлттэйгөө холбогдуулаад нэлээн олон

зүйл тусгачихсан юм билээ. Тэрийгээ бид эргэж харах ёстой байх. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохолж.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Бас анхаарах ёстой шүү Төрийн албаны тухай хуулийг бид нар хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд, хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ. Одоо Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Сайн байцаана уу? Өдрийн мэнд хүргэе. Өглөө бас чуулган дээр нэлээн үг хэлсэн бүгдээрээ мэдэж байгаа даа олон жил яригдаж байгаа асуудлууд. Одоо төсвийн таналт гээд хийгдэх нь байна шүү дээ 1.9 их наяд. Орлого бол магад 3.3 их наядад хүрэх байх гэсэн тооцоолол байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 3.3 их наядаас ч их гарчих юм уу. Ер нь 3 их наядаар эр их гарчихвал 2 их наядын таналт чинь хангалттай байж чадах эсэхэд хүмүүс эргэлзэж байгаа. Энэ цаг үед Төсвийн байнгын хороог иргэд, олон нийт ер нь бусад гишүүд ч гэсэн болгоомжтой харж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр манай хариулт өгч байгаа төрийн албан хаагчид маань, сайд нар маань маш тодорхой хариулчихвал хэн хэндээ бас их дөхөмдөө юм уу. Гишүүд чинь бас зөв зүйтэй, бүтээмжтэй ажиллуулчих гээд дэмжиж байгаа гэдэг үүднээс хараарай. Тэгэхгүй гишүүд зөвхөн улс төрчийн ажил энэ дотор хийдэггүй гэдгийг жишээлбэл би хувь хүнээ төлөөлөөд хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт нь тэр хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 12 хувьтай байна гэдэг дээр бас анхаарч өгөөрэй. Тэр төрийн чиг үүргийн давхардал, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх энээ тэрээ гээд олон жил ярьсан. Миний гол хэлэх гээд байгаа санаа нь нэгэнт 530 тэрбумаар хасаж байгаа нэмээд хасаж болох төслүүдийг хараарай гэдэг дотор хамгийн гол нь тоног төхөөрөмжүүд олноор нь, ихээр нь авах гээд байгаа тэр асуудлуудыг хараарай гэж хэлэх гээд байгаа шүү эксел шийт/Excel sheet/-ээ өөрсдөө анзаараад.

Өөр бас хэлэх гэж байгаа юм нь энэ санал хүмүүсийн бас бид нар чинь иргэдийг төлөөлж байгаа юм чинь санал ирнэ. Тэр дотор юу гэж хэлж байна вэ гэхээр Налайхад байдаг Герман Монголын хамтарсан Жи Ай Зи /GIZ/гээд их сургууль байгаа шүү дээ. Инженерүүдийг бэлдэж байгаа Англи хэл дээр маш хэрэгтэй ийм их дээд боловсролыг Монгол улсдаа хөрөнгө оруулалтыг татах замаар дэмжих сайн эхлэл гэж харж байгаа. Тэр дээр 2 Засгийн газрын хоорондоо байгуулсан гэрээний өмнө Монголын Засгийн газар хүлээсэн үүрэг байгаа. Тэр төсвөөс хасна гэж байгаа нь өөрөө бас учир дутагдалтай.

Цаашлаад бас 2 улсын дипломат харилцаанд сэв суух вий гэсэн ийм асуудал хөндөгдөхөөр байна шүү. Тэгэхээр бүх юм хөрөнгө оруулалт ч бай, урсгал зардал ч бай том тоогоор биш энэ бусад гишүүд ч гэсэн асуугаад байна шүү дээ яг юуг, хэрхэн, яаж, яагаад гэдэгт сайн хариулаарай гээд асуугаад байгаа. Тэр дээр л маш тодорхой, маш ийм нухацтай сууснаа батлахуйц хариулдаг. Тэр дээрээ маш их анхаарч ажиллаарай л гэсэн ийм үг хэлээд дуусгая гэж бодож байна.

Ц.Даваасүрэн: Чухал санал хэллээ. Энэ хуучин ер нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсвийн гүйцэтгэлийг намрын чуулган эхлэнгүүт гишүүд шаардаж оруулж ирж ярьдаг байсан байхгүй юу. Сүүлийн 2 парламент дээр ерөөсөө ийм юм болсонгүй. Энэнээс харахад ер нь гишүүдийн хариуцлага суларсан, Их Хурлын чанар нь муудсаны л илрэл шүү дээ тэр. Тухайн үед би Сангийн яаманд ч байх ч гэсэн бид нар намар яг намрын чуулган эхлэхэд төсвийн гүйцэтгэлийг оруулж ирж гишүүдэд танилцуулдаг байсан байхгүй юу. Хөрөнгө оруулалтыг 60-аас дээш

хэтрэхгүй байна гээд л баахан загнуулж аваад л гардаг. Тэгээд л хөрөнгө оруулалтынхаа ажилд энэ бүх яамнууд анхаардаг тийм байсан. Одоо тэгж байгаа гишүүн 1 ч байхгүй байна шүү дээ. Тийм учраас бас энэ дээр дуугарч байгаа нь зөв. Ойлгож эхэлж байна гэж би ойлголоо.

Би бас тэр гишүүнийхээ хувьд үг хэлэхэд энэ цомхотгол хүний амьдралыг бас шийднэ гэдэг чинь тийм амаргүй асуудал байхгүй юу. Зүгээр 8 хувь гээд л тээ. Сая би байгууллагуудаар болж байгаа процессуудыг надад чинь янз бүрийн гомдлууд ирж байна шүү дээ. Тэгтэл 2 хүний орон тоонд миний орон тоог нэгтгэчихлээ гээд л. Захаасаа авхуулаад эхэлчихсэн байна. Тэгэхдээ эцсийн дүндээ энэний буруутан бид нар төсвийг хэтэрхий тэлсний л асуудал шүү дээ. Дан ганц нүүрснээс хамааралтай эдийн засагтай байж байж төсвөө тэлээд л яваад л байсан. Тэр үед нь дуугарцгаагаагүй. Хэдхэн хүн л хэлсэн мань мэтийн болохгүй шүү дээ гэж. Одоо энэний бүх гайг хөөрхий хэдэн төсвийн албан хаагч нар үүрч гарч байгаа байхгүй юу. Гарах болж байна шүү дээ. Энэ дээрээ нэг зүйлийг анхаараарай. Тэр гишүүдийн хэлээд байгаа тэр эмх замбараагүй, хууль бусаар орон тоогоо нэмчихсэн газруудыг нь л олж тэр төсвөө хэтэрхий ихэсгэчихсэн байгаа, ажил үүргийнхээ дагуу биш тэлчихсэн байгаа, Батжаргал гишүүний хэлээд байгаа шиг ажил үүрэг нь тодорхой бай, тэрнийхээ дагуу бүтцээ байгуул, хүнээ ав гээд байна шүү дээ. Зарчим ерөөсөө тийм шүү дээ. Тэгэхгүй илүү дутуу баахан ажил хийдэг орон тоо бий болгочихсон, бүтэц бий болгочихсон байгаа юмнуудаа л олж халах ёстой болохоос биш зөв явсан төрийн албыг ингэж болохгүй л дээ. Наад дотор чинь байна шүү дээ маш чухал ажил хариуцаж байгаа хүмүүс хүртэл хамрагдаж байж магадгүй байхгүй юу энэ дотор чинь. Та нар 9 оныг санаж л байгаа биз? 9 онд яасан бид нар төсвийн зардлыг бүх байгууллагаар 10 хувиар нь танасан. Эмнэлэг дээр яасан 14 хүүхэд эндсэн. Яагаад вэ? Хүйн халдварынхаа бодисыг авахаа больсон. Анхан шатны хэмнэлтээ тэд нар тэгж хийсэн. Нялхсын ариутгалын бодисыг авахгүй болж хийсэн. Тэгээд бид нар 14 хүүхдээ амиар төлсөн. Би энийг байнга хэлдэг. Тийм учраас механик хасалт гэдэг юмыг ер нь бас хийж болохгүй шүү. Тэр гишүүдийн хэлээд байгааг та нар бас анхаараарай. Пүрэвдаваа гишүүн ч гэсэн сая анхааруулж байна шүү дээ.

Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Энэ чинь дага дагаж байгаа хууль бүрээр санал хураалт явна. Санал хураалтад бэлтгэе. Болдоггүй юу? Дахиад үз хүлээ. Бэлэн болсон уу? Би бэлэн болгодог юмыг нь хэрэглээдэхье тэгвэл. Чамд туслаадахъя. Оров уу? Эндээс би үзье дээ.

Гишүүд бэлэн болсон байна. Санал хураалтдаа оръё.

Эхний санал хураалт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 3 хууль, 2 хуулийн тогтоолын төслийн нэг болох Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль шүү.

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 57.9 хувиар энэ хуулийн төсөл дэмжигдлээ.

2 дахь хуулийн төсөл. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцсон. 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар Төрийн албаны тухай хуулийг хэлэлцэхийг дэмжлээ.

3 дахь санал хураалт. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ чинь хэлэлцэх эсэх.

4.“Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

5.“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцсон. 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Дагасан хуулиудын санал хураалт дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 3 хууль, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Түвшин танилцуулчих уу чуулганд?

Түвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Улсын Их Хурлын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

14.59 цаг

Хоёр дахь асуудалд оръё. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад ажлын хэсэг байгуулъя гэсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5-д Байнгын хороо шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, Байнгын хорооны тогтоол гарна гэж заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Энэ дээр нэмэгдээд харин Давын Цогтбаатар гишүүн саналаараа оръё гэсэн байгаа. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу?

Юу гэж энэ чинь болохгүй. Алга байна.

Санал хураалт явуулъя гишүүд ээ. Заяабал гишүүн нэмэгдэх юм уу айн? Байгаа биз дээ? Хасагдъя аа? Тэгж болохгүй гишүүд ээ. Хар аа ажлын хэсгийн ахлагч тогтоолын төслийг би та бүхэнд танилцуулаадахъя. Тогтоолын төсөлтэй танилцуулаагүй байна хөөе.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026, 2027 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгт ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг, Гишүүд Ж.Батжаргал, Булгаа яах юм? Булгааг үлдээлээ Г.Ганбаатар, Б.Заяабал, М.Мөнхсоёл, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин болих юм уу? Түвшингийн орон Цогтбаатар. Г.Тэмүүлэн, Дав.Цогтбаатар. Тэмүүлэн байгаа яах юм? Үгүй ээ чи байсан нь дээр ээ. Байгуулагдахгүй. Үгүй үгүй үгүй. Энэ энэ дээр бүгдийг нь яриад явах юм. Өөрөө байж байсан нь дээр. Бас туршлагатай хүн байх нь дээр.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэшсэн шинжээчдийг татан оролцуулж болохыг ажлын хэсэг Ганхуягт зөвшөөрсүгэй.

Ийм тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Одоо санал хураалтдаа бэлтгэе гишүүд ээ. Энэ үүгээр хургаагаад явж болно биз? Санал хураалтад бэлэн болсон байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 63.2 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Байгаа. Гурав дахь асуудал байгаа шүү. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Гурав дахь асуудал. Гурав дахь асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаа юу энэ дээр? Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга гэсэн ийм ажлын хэсэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Монгол Улсын Их Хурлын хуралдааны чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 7 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцэж эхэлнэ.

Зүйл бүрээр хэлэлцэнэ.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулан байна уу айн?

Алга уу? Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 1 санал гарсан байна. Мөн үү? Тийм байна.

Ж.Батжаргал гишүүн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан байна. Саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйл.

Төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэхтэй холбоотой 69¹дүгээр заалтыг хасах. Санал гаргасан Батжаргал.

Батжаргал гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Айн тэгвэл түр байж бай. Батжаргал гишүүн саналаа тайлбарлая. Батжаргал гишүүн саналаа тайлбарлая.

Ж.Батжаргал: 69 дүгээр зүйл юу яагаад байгаа юм аа, төсөв хэлэлцэх юуг оруулаад байгаа юм. Дэгийг 1 үе шат нэмэгдүүлээд байгаа юм. Өнгөрсөн жил Төсвийн тухай хуульд Төсвийн байнгын хорооны гишүүд сууж байгаад боловсруулалт хийж нэмэлт оруулахдаа төсвөө 9 сарын 1-нд өргөн бариад 10 сарын 1-ийг хүртэл Улсын Их Хурал Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд санал, дүгнэлт гаргуулахаар хүргүүлэх, тэр нь бас тодорхой цаг хугацааны цаглавартай байх, дээр нь хэлэлцүүлгүүд зохион байгуулах энэ бүх харилцаануудыг зохицуулаад оруулчихсан юм. Яг энэнтэй санаа бүх юмнууд давхардаад байна гэж ингэж үзэж байгаа. Одоо байж байгаа хууль нь яг энэ зохицуулалтаараа байж байгаа зүйл. Тийм учраас би тэр юуг хасах ёстой гэсэн ийм байдлаар саналын томьёолол гаргаж саналаа өгсөн гэж.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ энэ чинь зарчмын зөрүүтэй санал гаргасан хүн л тайлбарлах юм байна шүү дээ. Дэг зөрчигдөх юм байна. Болохгүй юм байна8 үгүй юм байна. Зөвхөн зарчмын зөрүүтэй санал гаргасан хүн хуулиа тайлбарлах юм байна. Энэ юу юм байна шүү дээ 39, 69 дүгээр зүйлийн 1 чинь 10 сарын 15-наас танилцуулга хийнэ гэдгийг л тэрийг хасъя л гэсэн үг.

Ер нь бол 9 сарын 1-нд өргөн барьчхаад тэгээд Байнгын хороогоор хэлэлцүүлэг хийж болж байгаа байхгүй юу одоогийн хуулиар. Өнгөрснөөр бол эрүүл мэндийн салбарын төсөв, мега төслүүдээр хэлэлцүүлэг хийсэн юм байна лээ. Тэгэхээр хэлэлцээд явах бүрэн боломжтой гэдэг агуулгаар тэгсэн байна.

Батжаргал гишүүний гаргасан саналын томьёоллоор, Батжаргал гишүүний гаргасан саналын томьёоллоор дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Бэлдэх ёстой юм уу айн? Гишүүд ээ ингэх юм байна эхлээд бэлтгэл хангах юм байна. Санал хураалтад бэлтгэе.

Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт гэдгээр 1 хэлэлцүүлэг хийсэн байна иргэдийн дунд Төсвийн байнгын хорооноос Их Хурал дээр. Дараа нь 14 мега төслүүдийн хөрөнгө оруулалтаар бас 1 хэлэлцүүлэг хийсэн байна. Тэгэхээр Байнгын хороо ингээд хэлэлцүүлэг хийгээд яваад иргэдийг оролцуулаад бүтэн 1 сарын хугацаагаар хэлэлцүүлэг хийж байгаа байхгүй юу. Одоо богиносгох гээд байгаа чинь буруу. Бэлэн болсон уу? Санал хураалтад бэлтгэе. Гишүүд ээ санал хураалтдаа бэлтгэе. Байгаа байхгүй юу. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. Санал хураалт. Санал хураалтаараа л шийдье л дээ. Хэнийг нь ч зөв байж болно, хэнийг нь ч буруу байж болно шүү дээ. Бид нарыг чинь энд мэтгэлцэж байгаад шийдэл гэж оруулж ирсэн. Санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд ээ бэлтгэе. 8-хан гишүүн байна. Санал хурааж болохгүй байна. Ороогүй байна тээ ороогүй байна шүү дээ. Бэлэн бус нь энэ биз дээ? Бэлэн бус байна. Батжаргал болсон байна, Ганзориг болсон байна, би бас, Заяабал энд болоогүй юм байна уу? Дамдинням гишүүнийх болоогүй байна. Ганхуяг гишүүнийх болоогүй байна шүү дээ. Ороогүй байна. Ганхуяг гишүүн болоогүй байна. Дамдинням гишүүн болоогүй байна. Одоо болчихсон уу? Ганхуяг гишүүнийх орохгүй байна. Дамдинням гишүүнийх орохгүй байна. Ороогүй байна ороогүй, энд ороогүй байна. Одоо Дамдинням гишүүн орсон тээ? Ганхуяг гишүүн орсон байна. Одоо санал хураалтад. Цогтбаатарын,

Баясгалан эд нарыг дуудчихмаар байна. Энэ бас хариуцлагатай санал хураалт учраас. 10 хэдэн гишүүн болгочих. Тэгэхгүй энэ чинь 19-өөс болохгүй болчхоод байна. Олуулаа бүртгүүлчхээд. Гишүүдээ оруулъя, ирцээ бүрдүүлъя.

Санал хураалтад бэлтгээрэй. Бэлдчихсэн үү байна уу? Аубакир байгаа юм уу? Байхгүй байна шүү дээ. Ороогүй байна дахиад шинэчилъе. Орчихлоо. Болормаа гишүүн орсон уу? Орсон.

Батжаргал гишүүний гаргасан горимын саналыг дэмжъе гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, 26.3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

4 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

5 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

5 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна.

6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

6 дугаар зүйлтэй холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

7 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн байна уу?

Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Төслийг зүйл бүрээр хэлэлц хэлэлцье.

Сая манайхан сайн ойлгохгүй л шийдэж байгаа юм. Тэгж 5 хэлэлцүүлэгтэй болгож хэрэггүй л байхгүй юу. 30 жил зүгээр явж ирсэн юмыг. Манай гишүүд сая юмаа анхаарахгүй юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дахь зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Айн? Дэгээрээ, 4 зүйлтэй зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Энэ төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжийг энэ Тогтвортой байдлын зөвлөл рүү шилжүүлэх гэж байгаа юм байна гэж харагдаад байна л даа. Тэгэхээр бид нар чинь өөрснөө ер нь мэдээллээ хаанаас авдаг болох юм? Энэ чинь бид нарын хувьд яг гишүүдийн хувьд мэдээлэл өгдөг цорын ганц институт шүү дээ. Ер нь хэдхэн л хүн байгаа. Энийг татан буулгаж Тогтвортой байдлын зөвлөлийг шилжүүлж яах гэж байгаа юм? Үгүй гэж энэ чинь яг тэгээд л биччихсэн байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ хяналт, шаналгаа, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийг татан буулгах гэж байгаа асуудал биш юм. Улсын Их Хуралд өргөн барьсан хууль дээр Үндэсний аудитын газар төсвийн хувьд Үндэсний аудитын газар аудит хийж байгаа. Дээрээс нь манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг бид нар энэ ялангуяа дагалдах хуулиуд дээр нэлээдгүй мэдээллээ хүргэхгүй байна гэсэн асуудлууд байсан. Бид нар төсөвт тогтвортой байдлын зөвлөлийн даргын дүн шинжилгээг сонсьё, Үндэсний аудитын газрын Ерөнхий аудиторын дүн шинжилгээг сонсоно. Ахиад дээрээс нь Хяналт шинжилгээ үнэлгээний газар ахиад дүн шинжилгээ хийх болчхоод байгаа байхгүй юу. Та бүхэн санаж байгаа бол сая энэ юун дээр төсөв дээр чинь их олон гишүүдийн бас бухимдаад байсан нь хоорондоо их зөрчилтэй их олон дүгнэлтүүд гаргаад байх юм. Ямар учиртай юм бэ гэдэг асуудлыг бас гишүүдээс бас яриад байсан. Манай Баасандорж дарга нэмээд Ерөнхий нарийн бичгийн дарга

Ц.Даваасүрэн: Ингэе энэ зөв шүү. Энэ зөв.

Х.Булгантуяа: Тэгэхгүй бол хурал бас эрхэнд халдаад байна гэдэг асуудал хүртэл гарч байсан. 1 номер манай Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга хариулаадахъя.

Яах юм яах юм. Ингэе.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс энэ чинь хариулж болно шүү дээ.

Ц.Даваасүрэн: Энэ дээр байна шүү дээ энэ энэ орж ирж байгаа санал зөв шүү. Яагаад гэвэл энэ Тамгын газар чинь өөрөө төсвийн 1 ерөнхийлөн захирагч байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө ямар ч хуулиар олгогдоогүй эрхээр төсөвт дүгнэлт өгч болохгүй байхгүй юу. Үгүй үгүй Байнгын хорооны харьяа биш. Тамгын газар болохгүй болохгүй. Тийм учраас энэ орж байгаа өөрчлөлт бол зөв. Хэдүүлээ ингээд л хэлэлцээд л явъя. Булгаа байж бай би санал хураалт явуулъя. Би зөв юмыг чинь дэмжээд л явна, буруу юмыг чинь буруу гэдгийг нь хэлээд л явна.

Энэ чинь хэддүгээр зүйл билээ? 1 дүгээр зүйл тээ? Энэ хуулийн Хяналт шалгалтын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

3 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

4.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? 1 дүгээр?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. Зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

5.Төсвийн тогтвортой байдлын тухай өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

1 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу?

Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна.

Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Алга байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын ч чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хороонд хэн байгаа юм ? Байхгүй юм уу? Хэнийг томилох вэ? Болохгүй. Болормаа гишүүн унших уу Төрийн байгуулалтын байнгын хороонд?

Болормаа гишүүн уншихъя. Чи ажлын хэсэгт байсан юм чинь.

Байнгын хороогоор хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Гишүүдэд баярлалаа.

Тэгэхдээ ер нь саяын хуулиуд дээр анхаараарай дэгийн хууль шүү Их Хурлын. Та нар ийм хууль дээрээ 1 жил болоод л өөрчлөөд байдаг ийм байж болохгүй шүү дээ. Дараа жил ахиад л өөрчилнө аягүй бол.

15.22 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР